

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Баасан гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>		
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>		1-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>		4-22
1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг		4-22
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай/		22

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны  
11 дүгээр сарын 22-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Одонтуяа;  
Чөлөөтэй: Х.Баттулга, Х.Баасанжаргал, Л.Мөнхбаатар, М.Нарантуяа-Нара;  
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Пүрэвдорж.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Үнэнбат, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Я.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр, П.Сайнзориг, Б.Заяабал, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Да.Цогтбаатар, Б.Энхбаяр, Ж.Алдаржавхлан, Г.Уянгахишиг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

**Д.Цогтбаатар:** Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 0  
Бүгд: 14  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсныг мэдэгдэж, дээрх санал хураалтад тус гишүүний саналыг “дэмжсэн”-ээр авсан болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Томилгооны сонсголын товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** “Томилгооны сонсголын товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 1  
Бүгд: 15  
93.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Хуралдаан даргалагч Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсныг мэдэгдэж, дээрх санал хураалтад тус гишүүний саналыг “дэмжсэн”-ээр авсан болно.

*Уг асуудлыг 14 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 08 минут үргэлжилж, 22 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 23 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
13 цаг 15 минут.

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье. Байнгын хорооны гишүүдийн, энэ чинь би өөрөө ороогүй байж байна одоохон. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдааны ирц 59,1 хувьтай байна. Байнгын хорооны дараах гишүүд ирж оролцож байна. Д.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, Б.Заяабал, О.Номинчимэг, У.Отгонбаяр, Б.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, Г.Уянгахишиг, Да.Цогтбаатар, Б.Энхбаяр гэсэн гишүүд ирж оролцож байна. Ингээд 59,1 хувьтайгаар хуралдаан эхэлж байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 2 асуудал хэлэлцэхээр байгаа. 1 дүгээр асуудал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг, 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн байгаа. 2 дахь асуудал нь Байнгын хорооны тогтоолын төсөл Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай ийм тогтоол байгаа.

Ингээд хэлэлцэх асуудлаар, тийм өөрчлөх гэж байгаа энэ 2 дахь юуг тийм. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Нэрсээ өгнө үү. Алга байна. Тэгвэл ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

### **Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Занданшатар, Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Даваадалай, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Мөнхболд гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирж, оролцож байна хуралд.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн, одоо ингээд холбогдох асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын

газрын дарга Г.Занданшатар дарга танилцуулна. Занданшатар даргад микрофон өгье. 5 дугаар микрофон.

**Г.Занданшатар:** ХЗБХ-ны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12.8 дахь хэсэгт заасан бүрэн эрхдээ үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдэд бүхэлд нь хориг тавьсан.

Үндэслэлүүдийг тодруулбал: 1 дүгээрт гадаад зах зээлийн төлөв байдал, түүнээс шалтгаалсан түүхий эдийн үнийн хэлбэлзлийг харгалзан гадаад валютын улсын нөөц, төсвийн хуримтлалыг нэмэгдүүлэх шаардлага, өрийг бууруулах суурь зарчмуудыг анхаарч, мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж, алдагдалгүй төсөв батлах нь зүйтэй байна гэж үзсэн. Олон улсын геополитик, геостратегийн нөхцөл байдал, зөрчилдөөн сөргөлдөөнөөс шалтгаалж түүхий эдийн үнэ, гадаад эдийн засгийн төлөв байдал урьдчилан таамаглах боломжгүйгээр хувьсан өөрчлөгдөж байна. Үүнээс шалтгаалаад түүхий эдийн үнийн хэлбэлзэл, үнэ ханшийн хэлбэлзэл өндөртэй байна. Энэхүү эгзэгтэй цаг үед мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж, үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй, хөгжилд хөтөлсөн төсөв батлах шаардлагатай гэж үзээд энэ бол нийт иргэн, улсын эрх ашиг сонирхолд бүрнээ нийцнэ гэж үзсэн. Ингэж алдагдалгүй төсөв баталж, мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлэх нь эдийн засгийн болзошгүй аливаа хүндрэл бэрхшээлүүдийг хохирол багатай даван туулах нөөц боломж, хуримтлалыг нэмэгдүүлэх, үнэ ханшийн өсөлтийг хязгаарлах, эдийн засгийн тогтвортой байдал, иргэд, аж ахуйн нэгж, татвар төлөгчдийн хэвийн ажиллагааг хангах баталгаа болно.

Мөн төсөв батлах процесс үйл ажиллагаа хуулийн зөрчилтэй гэж үзсэн. Тухайлбал Монгол Улсын Их Хурал 2025 оны төсвийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, хуулийн 6.5.1-д заасан төсвийг хэлэлцэн батлах үйл ажиллагаа нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх.

Мөн Төсвийн тогтвортой байдлын 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан төсвийн бодлого, стратегийн зорилт нь макро эдийн засгийн болон татварын тогтвортой орчныг бүрдүүлэх, инфляцыг хязгаарлахад чиглэгдсэн байх ёстой. 5.1.6-д заасан төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх гэсэн заалтуудыг бүрэн хангаагүй бөгөөд энэ байдал нь хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчимд нийцэхгүй байна гэж үзэж байна.

Үүний зэрэгцээ Улсын Их Хурлаар саяхан баталсан, 3 сарын өмнө баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлана гэж заасан зорилтоо бодитой хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тэргүүн сануулж байна.

Мөн ард иргэд, баялаг бүтээгчид, татвар төлөгчид, мэргэжлийн байгууллагуудын зүгээс төсвийн сахилга батыг чангатгах, үр ашигтай, хэмнэлттэй

байх зарчимд нийцүүлэн төсвийн зардлыг бууруулах, чиг үүргийн давхардлыг арилгах, мөн улс төрийн нам, эвслүүд сонгуулийн амлалтаа биелүүлэх зэрэг санал шүүмжийг илэрхийлж байгаа нь зүй ёсны шаардлага хэмээн бодож байна.

2-т Монгол Улсын төсвийн тухай хууль тогтоомж нь 2025 оны Төсвийн тухай хууль тогтоомжууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байна гэж үзэж байна. Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн хуулийг баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 41 дүгээр тогтоолыг баталсан. Энэ тогтоолоор 2025 оны төсвийн тухай энэ хууль нь Төсвийн болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан зарчмын шаардлагуудыг хангаагүй, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж чадаагүй, Төрийн мөнгөний бодлогод нийцээгүй болохоо үндсэндээ хүлээн зөвшөөрсөн. Тийм учраас батлагдсан төсвийг 12 сард багтаан тодотгож, дахин засаж сайжруулах шаардлагатай гэсэн агуулгыг илэрхийлсэн ийм тогтоол баталсан.

Гэтэл Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт ЗГ тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан байдаг. Гэтэл Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчин төгөлдөр болж, дагаж мөрдөж эхлээгүй, хэрэгжих явцад нь Төсвийн тухай хуулийн 34.1-д заасан нөхцөл байдал тодорхой тохиолдлууд үүсээгүй байхад Улсын Их Хурал төсөвт тодотгол хийхээр баталж, чиглэл болгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээх заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байна гэж үзэж байгаа.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу төсөв, татварын анхдагч хуулийг санаачлах онцгой эрхийг гагцхүү ЗГ-т олгосон бөгөөд 19 оноос хойших Үндсэн хуулийн эрх зүйн орчинтой 41 дүгээр тогтоол үндсэндээ зөрчилдсөн. Иймд дээрх үндэслэлээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжуудад бүхэлд нь Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан бөгөөд хоригийг холбогдох хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Д.Цогтбаатар:** Занданшатар даргад баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Да.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

**Да.Цогтбаатар:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхийлөгчийн Тамгын газраас яг энэ нэг үг хэллэгтэй холбоотой гэх юм уу нэг асуулт иргэдэд илүү ойлгомжтой байх талаас асууя. Энэ 1 дүгээр зүйл хоригийн 1 дүгээр зүйлд энэ алдагдалгүй төсөв батлах нь зүйтэй гэж байгаа. Энэтэй бол бүрэн санал нийлж байгаа. Тэгээд энэтэй холбогдуулаад мөчлөг сөрсөн төсвийн бодлого гэж хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн үндэслэлээр хоригийн 1 дүгээр зүйлд тусгагдсан. Энийг илүү дэлгэрэнгүй ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгнө үү гэж.

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофон.

**Г.Занданшатар:** Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Мөчлөг сөрсөн төсвийн бодлого нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл, гадаад зах

зээлийн нөхцөл байдлаас шалтгаалаад энэ хэлбэлзлийг сөрсөн бодлого хэрэгжүүлж байхыг манай өнгөрсөн хугацааны төсвийн алдагдал, өрийн нөхцөл байдал, дефолт үүсэж байсан нөхцөл байдлууд харуулсан. Тухайлбал 2011 онд зэсийн үнэ 8450 долларт хүрч, орилох үедээ хүрч байх үед төсвийг хэт тэлснээс шалтгаалаад 2016 онд зэсийн үнэ 4520 доллар болоход улс орны өрийн байдал дефолт зарлаж Олон улсын валютын сангийн standby хөтөлбөрт хамрагдаж, ямар хүндрэлтэй санхүү, төсвийн нөхцөл байдалд орсон бэ гэдгийг энэ төсвийн мөчлөгөөр харгалзаж үзэж байна. Ийм учраас төсвийг тэлэх, түүхий эдийн энэ өсөлтийг дагаж төсвийг тэлэхгүй, мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж байх зарчимд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.13-д өнгөрсөн парламент суулгасан байсан. Энэ 6.1.13-ыг сая хүчингүй болгож байгаад, энэ төсвийг хэт тэлэх бодлого ер нь мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх нь шаардлагатай.

Өнөөдрийн нөхцөл байдал бол урьдчилан таамаглаж болзошгүй орлого нэмэгдэх юм уу, буурах юм уу, түүхий эдийн үнэ яг хэд болохыг энэ сүүлийн үеийн сонгуулиудын нөхцөл байдал, олон улсын геополитик, зөрчилдөөний нөхцөл байдлууд тодорхойгүй байгаа үед энэ үед бол мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж, алдагдалгүй төсөв батлах нь улс орны, нийт ард түмний эрх ашигт бүрнээ нийцнэ гэж үзэж энэ мөчлөгийг харуулж байгаа юм. Тэгэхээр мөчлөгийн цикл бол дандаа өгсөж, уруудаж явсан түүхий эдийн үнийн цикл. Сүүлийн үед болзошгүй худалдааны дайнаас үүсэж, хөрш орнуудад нөлөөлж болзошгүй нөхцөл байдал бол энэ мөчлөгийн хэлбэлзэлд бас хамаарна гэж үзсэн.

**Д.Цогтбаатар:** Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Ерөнхийлөгчийн хоригийн агуулга 25 оны бидний баталсан улсын төсвийн хууль 1,9 их наядын алдагдалтай төсөв, Ерөнхийлөгчийн хоригийн агуулга нь энэ алдагдлыг бууруул гэж байгаа юу эсвэл алдагдалгүй төсөв батал гэсэн агуулгаар орж ирж байгаа юу гэдгийг нэгд асууя.

2-т би ХЗБХ-ны даргаас бид нар чинь Төсвийнхөө хуулийг батлаад, ахиад Улсын Их Хурлын тогтоол баталчихсан. Төсөвт тодотгол хийх. Хэрвээ Улсын Их Хурал энэ хоригийг хүлээж авбал энэ тогтоолыг яах вэ? Тодотгол хийгдэх үү, энэ Их Хурлын тогтоолыг хүчингүй болгох уу? Ийм асуудал үүсэж байна. Тийм учраас энэ дээр манай ХЗБХ дараагийн асуудал нь юу гэж үзэж байгаа юм бол гэсэн ийм 2 асуулт байна.

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофоныг өгье.

**Г.Занданшатар:** Ерөнхийлөгчийн хоригийн 1 дүгээр зүйлд алдагдалгүй төсөв батлах нь зүйтэй байна гээд тов тодорхой тийм шаардлагыг тавьсан. 2018 онд эдийн засгийн байдал маш хүнд байхад Улсын Их Хурал алдагдалгүй төсөв баталж байсан түүх бий. Өнөөгийн энэ тодорхойгүй нөхцөл байдал бол төсвийн хуримтлалыг бий болгох, төсвийн урсгал зардал болон энэ валютын ханш үнэ ханшид нөлөөлж болзошгүй байдал, төлбөрийн тэнцэлд үзүүлж байгаа стресс шок энэ бүхнийг харгалзан үзээд алдагдалгүй төсөв батлах нь зүйтэй гэж үзсэн. 3,5 их наядаар өсөж байгаа урсгал зардал бол нийтдээ 53 хуулиас дагалдаж байгаа. Энэ цэргийн албан хаагч нар, юу олон тэтгэвэр, тэтгэмжийн хуулиудаас гадна бас урсгал зардал нэмэгдүүлсэн Боловсролын багц хуульд гээд үр ашиггүй зардлуудыг хэмнэх бололцоо, үр ашиггүй, зайлшгүй шаардлагагүй зардлуудыг



тэвчиж болох зардлуудыг тэвчих замаар энэ удаа бол бүсээ чангалаад, алдагдалгүй төсөв батлах нь зүйтэй гэж үзсэн.

**Д.Цогтбаатар:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ хориг энийг дагаж гарсан өнөө хамгийн сүүлийн paragraph нь ерөөсөө тэгж байгаа. Энийг дагаж гарсан бүх хууль тогтоомжууд дээр хамт хориг тавигдчихаж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ хоригийг хүлээж авснаараа тэр хамт гарсан хуулиудын, хуулиудад энэ тавигдсан хоригийг бас хамт хүлээж авч байна гэсэн үг нэг.

Хоёрт тэр тогтоолын нэг онцлог бол яг тухайн тэр хэмжээнд батлагдсан төсөвт зориулж гарсан тогтоол байхгүй юу. Одоо энэ чинь ингээд явцын дунд өөрчлөгдөж байгаа бол тэр тогтоол өөрөө угаасаа хэрэгжих боломжгүй болж байгаа юм. Тэгэхээр угаасаа энэ дээр хориг тавигдаагүй байсан ч автоматаар тэр өөрөө хүчингүй болоод бид нар шинэчилж батлахгүй л бол хэрэв шаардлагатай бол, шаардлагагүй бол энийг өөрчлөх ёстой. Тэр хориг, тодотгол хийхэд шаардагдах өөрчлөлт, одоо энэ хоригийг хэлэлцээд дуусахад шийдэгдчих юм бол тэр асуудал угаасаа өөрөө байхгүй болчихож байгаа байхгүй юу. Тэр өнцгөөсөө энэ дээр бол юу тэр тогтоол өөрөө өөрчлөгдөх л хэрэгтэй болно. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны төсвийн хуульд тавьсан хоригийг хүлээж авна. Хоригийг мэргэжлийн Байнгын хорооных нь хувьд бол Төсвийн байнгын хороо, хууль зүйн хувьд нь Хууль зүйн байнгын хороо хэлэлцдэг ийм дэгтэй. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт 2 газар Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн асуудлыг дурдсан байгаа юм. Тэгэхээр энд бол ХЗБХ дүгнэлт хийх ёстой. Тэр дотроо Монгол, 2025 оны төсвийн тухай хууль хүчин төгөлдөр болж дагаж мөрдөгдөөгүй байхад, Төсвийн хуулийн 34.1-д заасан тохиолдол үүсээгүй байхад тодотгол хийх тогтоол баталсан. Энэ нь Улсын Их Хурал хууль дээдлэх гэдэг зарчмыг зөрчсөн гэдэг ийм асуудал хөндөгдөж байгаа. Тэгэхээр ер нь муйхарлаж зүтгэж олон нийт, ард иргэд, бизнес эрхлэгчид удаа дараа мэдэгдээд байсан манай парламентын гишүүд ч дотроосоо удаа дараа хэлээд байхад, зүтгэсээр байгаад л энэ төсвийг ямар ч хөндөгдөлгүйгээр батлуулах ёстой гээд л батлуулсан шүү дээ.

Тэгэнгүүт сүүлд нь Ерөнхийлөгч хориг тавингуут Сангийн сайд гарч ирээд их баяртай хүлээж авч байна ч гэх шиг. Хэнийг доромжлоод байгаа юм бэ? Энэ 25 оны төсвийг баталсан гишүүдийг буруу шийдвэр гаргасан гэж хэлээд байгаа юм уу? Чи тийм ойлгомжгүй байдалд ярьж байна шүү дээ. Ер нь төсөв гэдэг бол нэг талаас хууль зүйн нөгөө талаас улс төрийн өөрөө үр дагавартай байдаг юм шүү дээ, энэ чинь бодлого байхгүй юу ЗГ-ын. Тэгээд энэ бодлого унаж байгаад ЗГ ямар дүгнэлт өгч байгаа юм бэ? Улсын Их Хурал ямар дүгнэлт өгч байгаа юм бэ?

Манай Улсын Их Хурлын гишүүд бол би буруу байхгүй гэж бодож байгаа. ЗГ чинь өөрөө үүгээр нь батална шүү гэж дөргүй гишүүдээр тийм чиглэл, улс төрийн шийдвэр гаргуулж байгаад л кноп даруулчихсан шүү дээ. Тэр кноп нь яг дарагдсан уу гэдэг эргэлзээтэй байгаа. Яг өнөөдөр 25 оны төсөв батлагдаад 14 хонож байгаа. Яг 2 долоо хоног. Би протоколыг нь авъя гээд өгөхгүй байгаа шүү дээ Тамгын газар. 14 хоног өгөөгүй байгаа. Тэр төсвийг баталсан гишүүдийн хэн гишүүн, ямар санал өгсөн бэ гэдгийг Тамгын газраас нэхээд өгөхгүй байгаа шүү дээ. Бичлэгийг нь ч өгөхгүй байгаа.

Тэгээд энэ тодотгол хийе гэдгийг хэдэн дарга яриад шийдчихдэг. Тэр үед миний мэдэхийн Сайнзориг гишүүн бид хоёр л наадах чинь Үндсэн хуулийн асуудал болно шүү гэж сануулж бичлээ шүү дээ. Арга ядаад сошиалд бичиж байгаа шүү дээ, сонсохгүй, хүч түрээд явахаар.

**Д.Цогтбаатар:** Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Төсөв батлах гэдэг бол Монгол Улсын ирэх жилүүдэд бид юуг хийх гэж байгаа, юунд фокуслах гэж байгаа, ямар зардлаар ямар ажлууд хийх гэж байгаа гээд бас нарийн ажил л даа. Энэ ажлуудыг улсын нэгдсэн төсөв батлагдсаны дараа орон нутгийн төсвүүд батлагдах гээд хүлээж байгаа. Аймгууд батална, нийслэл батална, үүний дараагаар сум, дүүргүүд батална гээд нэлээн цаг хугацаатай ажлууд ингээд хүлээгдэж байгаа. Тэгэхээр бид энэ дээр нэгэнт л ийм хууль, эрх зүйн процедурын гэдэг юм уу шинэ нөхцөл байдал гэж хэлж болохоор зүйлүүд гарсан учраас яаралтай явах нь зөв.

Ер нь 9 удаа төсөв дээр хориг тавьж байсан юм байна лээ Төрийн тэргүүн энэ өнгөрсөн хугацаанд, 92 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш. Энэ ингээд 10 дахь нь болж байна уу, 9 дэх нь үү ийм хавьцаа байна. Яах вэ энэ удаагийн хориг бол бид нарт энэ асуудлыг дахиад нэг ярилцах боломжийг олгож байна. Би яах вэ зүгээр ЗГ бол төсвөө өргөн барьсан гэж бодож байгаа. Энэ дээр ажиллах Улсын Их Хурлын гишүүд нь яг хангалттай ажилласан уу, үгүй юу. Ерөнхий байдлаар нэг хүний үгээр явж, төсөв дээр ерөөсөө 52 санал гаргасны бараг 20-иодыг нь л ажлын хэсэг гаргасан шүү дээ. Бусдыг нь Улсын Их Хурлын гишүүд гаргаад, яах вэ түүн дээр ингээд алдаатай томьёоллууд ч байсан, болох болохгүй юмнууд хураагдаад, ихэнх нь дэмжигдээгүй.

Тэгэхээр энэ ажлын хэсэг ийм үр дүнгүй ажилласнаас болж өнөөдөр нэг аль нэг институцийг би нэг их буруу зөрүү гэж хэлмээргүй байна. Бүхэл бүтэн 25 хүнтэй ажлын хэсэг гэдэг бол их том ажлын хэсэг гарсан. Тэгээд нөгөө ажлын хэсэгт ажилласан ажлын хэсгийн дарга хийгээд, ажлын хэсэгт ажиллаж байсан гишүүд нь шууд хоёрдугаар хэлэлцүүлгээс эхлээд улс төр хийж эхэлсэн. Ийм зүйл байж болохгүй. 126-гаага төлөөлөөд ажлын хэсэг ажиллаж гээд явчхаад, эцэс сүүлд нь бол үндсэндээ бүх гишүүд рүү чихээд, ЗГ луу чихээд явж байгаа нь бол харамсалтай. Бидэнд боломж хуулийн процедурын дагуу үндсэн асуудалдаа оруулж ирсэн асуудал дээр бид нар нэг талд нь гаргаад шийдэхээс өөр аргагүй байсан байхгүй юу.

Би тэгээд ер нь цаашдаа зүгээр хоригийг хүлээж аваад явах нь чигтэй явж байх шиг байна. Жижиг тойргийн гэдэг юм уу ийм эрх ашиг руу битгий явчхаасай л гэж бодож байна. Одоо ингээд 78 Сангийн сайд, магадгүй жагсаалтын хэд ингээд 126 Сангийн сайд болоод л жижиг, жижиг баахан үр дүнгүй юмнууд л тусгах гээд явах байх. Тэгэхээр би энэ чиглэлд л хамгийн том болгоомжлол байна. Тэгээд ер нь Улсын Их Хурлын Тамгын газраас хоригийг бол ерөнхийдөө ердийн хууль дээр бол нэг л үе шатаар хүлээгээд авчихдаг бол төсөв өөрөө онцгой хэлэлцэх процедуртай, 4 үе шатаар явдаг, ямар процедураар явах юм бэ гэдэг зүйлийг яг энэ чуулган руу хоригийг хүлээж авсны дараа маш тодорхой болгомоор байна нэг. 1 үе шатаар явах юм уу, 2 үе шатаар явах юм уу?

Энэ ч гэсэн бид нарын нөгөө цаашдаа Дэгийн хуулийг ч гэсэн сайжруулах нэг том чиглэл өгч байна. Тэгэхээр энэ дээрээ анхаараад явъя. Надад нэг их тийм асуулт алга.

**Д.Цогтбаатар:** Заяабал гишүүн.

**Б.Заяабал:** Миний хувьд бол энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ төсөв дээр тавьсан хоригийг бүрэн дэмжиж байгаа, хүлээж авч байна. ЗГ, Улсын Их Хуралд аль алинд нь анхааруулга өгсөн, санамж өгсөн ийм бас Улсын Их Хурлын гишүүн болоод Ерөнхийлөгчийн анхны хоригтой танилцаж байна. Би энэ хоригийг дэмжихээс гадна хориг дээр орж ирж байгаа зүйлүүдээс хэд хэдэн зүйл асуумаар байгаа юм. Сая манай гишүүд нэлээдгүй асуучихлаа.

Хууль зүйн талаасаа бол манай ХЗБХ бол яах аргагүй дүгнэлт өгөх ёстой Их Хурлын институт мөн үү гэвэл мөн. Гэтэл энэ төсөв дагаж орж ирсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр байдаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс орж ирсэн энэ дүгнэлт дээр энэ оруулж ирж байгаа төсвүүд чинь холбогдох хууль тогтоомжуудыг зөрчсөн байна шүү гэдэг ийм дүгнэлтүүд яг энэ орж ирсэн байгаа. Төсвийн байнгын хороон дээр энэ асуудлыг ярья гэсэн хэлэлцэх горим байхгүй гээд ингээд хэлэлцээгүй. Тэр нь ч өнөөдөр ингээд Ерөнхийлөгчийн хориг дээр дурдагдаж орж ирлээ.

Сая Энхбаяр гишүүн ярьж байна. Үндсэн хуультай холбоотой хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны зарчим алдагдсан байна гэдэг дээр Ерөнхийлөгч маш онцгой анхаарал хандуулж, энэ хориг дээр оруулж ирсэн байгаа. Тэгэхээр энэ дээр бол манай ХЗБХ цааш цаашид бид нар анхаарах ёстой юм болов уу гэдэг ийм зүйлийг хэлмээр байна. Энэтэй холбоотойгоор би нэг зүйлийг ХЗБХ-ноосоо асуучихмаар байгаа юм.

Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваад, Улсын Их Хурлын шийдвэр гарсны дараагаар энэ төсвийг ЗГ луу буцааж болдог уу гэдэг ийм асуулт надад байгаад байгаа юм. Яагаад гэвэл ЗГ-ын өргөн барьчихсан энэ хуулийг одоо Ерөнхийлөгчийн хоригийн дагуу Улсын Их Хурал өөрчлөх юм бол нэлээдгүй том өөрчлөлтийн асуудал цаана нь яригдана. Нөгөө ЗГ-ын үйл ажиллагааны чинь бодлого нь байхгүй болох асуудал болох уу? Улсын Их Хуралд ийм хэмжээний боломж байгаа юу гэдэг ийм асуудал 1 дүгээрт байна.

2 дугаарт нь энэ Улсын Их Хурлын Тамгын газрын энэ Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийн дүн шинжилгээний дүгнэлтээр энэ төсвийн энэ удаагийн төсөв нь хууль, эрх зүйд нийцэж байна гэсэн ийм дүгнэлт гаргаад өгчихсөн. Гэтэл сая Ерөнхийлөгчийн хориг дээр энэ чинь болоогүй байна гэдэг ийм хориг орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар хариулт байгаа юм бэ гэж?

3 дугаарт нь энэ Ерөнхийлөгчийн Тамгын газраас би асуумаар байгаа юм. Яг энэ Төсвийн тогтвортой байдлын бодлогын зөвлөлийн дүгнэлт дээр энэ Төсвийн тухай хууль зөрчигдсөнөөс, Төсвийн болон Тогтвортой байдлын тухай хууль зөрчигдсөнөөс гадна хос алдагдлын мөчлөгт орох ийм боломж үүссэн байна шүү гэдэг ийм дүгнэлт орж ирсэн байгаа юм. Тэгээд би сая энэ мөчлөг гэдэг үгийг асуухдаа энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн оруулж ирсэн энэ хос

алдагдлын мөчлөг гэдэгтэй хэр зэрэг нийцэж байгаа юм бэ? Энийг бас хүлээн зөвшөөрч байгаа юу гэдэг ийм асуулт асуухыг хүссэн.

Дараагийн нэг асуулт бол Ерөнхийлөгчийн Тамгын газраас энэ алдагдалгүй төсөв батал гэдэг ийм анхааруулга оруулж ирсэн байгаа. Хэрвээ алдагдалтай төсөв батлагдах юм бол.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Тодотгох уу? 1 минут нэмж өгье Заяабал гишүүнд.

**Б.Заяабал:** 2 дахь асуулт нь сая микрофонд орсонгүй. Ерөнхийлөгчийн хориг дээр бас нэг тавигдсан зүйл нь энэ мөчлөгөөс гадна энэ алдагдалгүй төсөв батлах ийм зарчим орж ирсэн байгаа. Их Хурал маань хэлэлцээд төсвийн энэ хоригийг хүлээж аваад, хэлэлцээд алдагдалтай байдлаар төсвийг дахиж батлагдах юм бол дахиад Ерөнхийлөгчийн зүгээс хориг тавина гэж ингэж ойлгогдохоор байна л даа. Энэ дээрээ бас давхар тодруулга нэмэлт хариулт өгөөч гэсэн ийм 2 асуултыг Ерөнхийлөгчийн Тамгын газраас, 2 асуултыг ХЗБХ-ны даргаас асууя? Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофон өгье.

**Г.Занданшатар:** Үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд ч тэр, аливаа хориг Үндсэн хуулийн хяналт тэнцлийн механизм бол хууль тогтоох байгууллагын санаатай болон санамсаргүй алдааг засахад чиглэгддэг. Энэ хоригоор төсвийн тодотгол аймаг, орон нутгийн төсөв батлагдах процессыг бас хөнгөвчилсэн гэж хэлж болно. Хэрвээ би алдаагүй бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90.8, 90.9-д зааснаар хоригийг хүлээж авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид Байнгын хороо, холбогдох Байнгын хороо хууль санаачилж хэрэгжүүлж болдог. Энэ дотроо Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн хуулиас авхуулаад тэр төсөв нэмэгдүүлсэн, урсгал зардал нэмэгдүүлсэн гээд байгаа тэр 53 хуулийг авч үзэх эрх нь өөрөө нээлттэй болж байгаа юм, ЗГ чадахгүй. 2 дугаарт нь Дэгийн тухай хуулийн 90.8, 90.9-ийн дагуу хэлэлцэх нь энэ цаг хугацааны хувьд илүү боломжийг олгож байна гэж үзнэ.

Заяабал гишүүний асуусан хос алдагдлын мөчлөг болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн энэ санал шаардлагууд, иргэний нийгмийн байгууллагууд, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын байгууллагуудын саналыг бид мэргэжлийн байгууллагуудын тавьж байгаа шаардлагыг зөв зүйтэй гэж үзэж байна гэдэг нэг үгээр томъёолсон. Ийм учраас хос алдагдлын мөчлөг бол дандаа өрийг нэмэгдүүлж, манай өрийн тогтворгүй байдал, эрсдэлийг нэмэгдүүлж ирсэн. Ер нь 25 жил хос алдагдалтай явж ирсэн жилүүдийн улмаас л манай эдийн засаг дефолт зарлах хэмжээнд хүрч, ОУВС-д хандаж ийм хүндрэлтэй нөхцөл байдалд ингэж шахагдаж байсан түүхүүдтэй. Тийм учраас өнөөгийн энэ таамаглаж болзошгүй гадаад, дотоод орчин, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс ихээхэн хамааралтай манай төсөв, эдийн засгийн байдал бол зайлшгүй энэ хос алдагдлын мөчлөгийг сөрж, алдагдалгүй төсөв батлах шаардлагатай гэж үзэж байгаа юм. Тийм ч учраас хэрвээ Ерөнхийлөгчийн тавьсан шаардлагууд хангагдахгүй болбол ахиж хориг тавихыг үгүйсгэхгүй. 2 дахь асуудлын хувьд Даваадалай зөвлөх хариулчих уу?

**Д.Цогтбаатар:** 4 дэх микрофон өгье.

**Б.Даваадалай:** Заяабал даргын хос алдагдлын асуудал дээр нэмэлт тайлбар өгье. Төлбөрийн тэнцэл эхний 9 сарын байдлаар 250 сая долларын алдагдалтай байгаа. Яг өмнөх жилийн өмнөхөөс 1 тэрбум доллароор муудсан гэсэн үг. Импортын өсөлт бас нэлээн өндөр байгаа. Мэргэжлийн байгууллагуудын тооцоогоор 26 онд төлбөрийн тэнцлийн асуудал нэлээн хүнд болох ийм шинжтэй байгаа. Тийм учраас эдийн засгийн агуулгаараа эдийн засгийн тогтвортой байдал нэг номер шүү гэдэг байдлаар энэ мөчлөг сөрсөн бодлогыг тавьж байгаа юм.

Хөгжлийн төсөл, хөтөлбөр томоохон юмнуудаа явуулахыг дэмжиж байгаа. Гэхдээ тогтвортой байдлаа хадгалахгүй бол үр дүнд хүрэхгүй гэдэг ийм том агуулга байгаа. Тийм учраас төлбөрийн тэнцлийн нөхцөл байдал, импортын өсөлт өндөр байгаа, эдийн засгийн агуулгаараа ийм зүйлүүдээс сэргийлж, тогтвортой байдлыг нэг номер болгож байгаа шүү гэдгийг нэмж хэлье танд.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Юун дээр Байнгын хорооноос асуусан асуулт дээр би хариулъя. Энэ одоо яг ингээд байгаа хуулиараа, одоо энд байгаа манай хуульч гишүүд энийг жинхэнээсээ бодох ёстой асуудал гараад ирж байгаа юм. Яагаад гэвэл энэ хоригийг хүлээгээд авчихаар урьд өмнө байгаагүй прецедент үүсэж байгаа юм. Ерөөсөө хүлээж авч байгаагүй юм билээ. Тэгээд хүлээж авч байгаагүй учраас энэ 90-н, 90-д байгаа заалтууд хэрэглэх шаардлага гарч байгаагүй гэсэн үг. Одоо хүлээгээд авчихаар 2 хувилбар гарч ирж байгаа юм. Сая Занданшатар даргын ярьж байгаа энэ 90-д байгаа заалт.

Гэтэл энэ дээр нэг асуудал байгаа юм. Энэ нөгөө 90-д байгаа заалт чинь хориг тавьсан ямар ч хуульд харьяалагдаж байгаа. Төсвийн хууль чинь өөрөө тусгай хууль бөгөөд ямар ч хуулиас шал өөр хууль болчихоод байгаа. Жишээлбэл энэ дээр төсвийн Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйл дээр энэ төсвийг зөвхөн ЗГ оруулж ирнэ гээд заачихсан байхгүй юу. Зөвхөн ЗГ. ЗГ-ын оролцоогүйгээр төсвийг бүгдийг нь зогсоочихсон байхад Их Хурал дангаараа аваад энэ бүгдийг нь хэлэлцээд явахад бол эргээд асуудал гарч болзошгүй болчихож байгаа юм. Энэ жишээлбэл энэ дээр ямар нэгэн тайлбар би тийм ямар шүүх биш энэ чинь өгч болохгүй.

Гэхдээ ийм тайлбарууд гарах эрсдэлүүд үүсэж байгаа байхгүй юу. Ердийн жишээлбэл хууль гишүүд өргөн барьчихсан хуулийг бол хэлэлцэх эсэхийг нь хэлэлцээд явдаг ийм энгийн хуулиуд байна шүү дээ. Тэгтэл Төсвийн тухай хууль бол бүр тодорхой заагаад өгчихсөн. Зөвхөн энэ этгээд энэ чинь нөгөө эрх мэдэл хязгаарлах юугаараа хуваарилагдчихсан байгаад байна шүү дээ. Төсвийг зөвхөн энэ этгээд оруулж ирээд, Их Хурал гүйцээгээд батална гэдэг. Тэгэхэд нөгөө хуулиудыг чинь бид нар авахаараа хэлэлцэх эсэхээс нь авхуулаад л дэс дараагаар нь явдаг байхад төсөв онцгой журамтай байхгүй юу, онцгой хууль учраас. Хэлэлцэх эсэх байдаггүй, шууд хэлэлцээд явдаг гэх мэт. Тэгэхээр энэ ердийн заалт энэ тусгай хуульд үйлчлэх үү, үгүй юү гэдэг асуулт ингээд өөрийн эрхгүй гарч байгаа. Надад лав хариулт байхгүй.

Энэ дээр өөр нэг чухал юм нь юу гэхээр Төсвийн хуулийг чинь бид нар оруулж ирж батлахдаа яаж байсан бэ гэхээр одоо энэ шинэ хуулийн чинь дагуу гишүүд дураараа авирлаж, төсвийг өөрчилдөг байсныг өөрчлөлтгүй болгож хязгаарлаж өгсөн шүү дээ. Тэгсэн энэ чинь бүхэлдээ тавигдсан хориг дээр бид нар Сангийн яамаа энд авчирч суулгаж байгаад хийчхэж болно л доо. Тэр чадах, чадахгүй тухай асуудал биш байхгүй юу. Аваад хийчихээр Засаг оролцоогүй, Их

Хурал төсвийг бүхэлд нь хэлэлцэж болох нөхцөл үүсэх гээд байгаа байхгүй юу. Ингэнгүүт энэ Төсвийн хуулийн нэг онцлог нь ямар ч төсөв оруулж ирэхэд 10 хувиас дээш өөрчлөгддөггүй. Энэ төсөв л гэхэд бараг тэр чигээрээ батлагдсан байхгүй юу. Тэгэхээр бараг 70, 80 хувь ЗГ-ын оруулж ирсэн төсөв байдаг учиртай. Нөгөө тэгж улс төржилт төсөвт оруулахгүй гээд заачихсан байгаад байдаг.

Тэгтэл энийг чинь аваад бид нар хэлэлцэх гэж байна. ЗГ-тайгаа оролцоод хийсэн ч гэсэн эрх зүйн хувьд Их Хурал 100 хувь өөрчилчих гээд байгаа байхгүй юу. Энэ үүд хаалга нээгдчих гээд энийг яаж шийдэх юм байгаа юм. Энэ дээрээ бид нар ёстой эрх зүйн хувьд тал талаасаа л ярих хэрэгтэй болж байгаа юм. Энэ дээр, тэгэхээр энэ бол бид нарын эхний тэр асуулт дээр бол яах аргагүй наад асуулт чинь өөрөө нээлттэй байж байгаа юм. 90-н, 90 дүгээр зүйлээ бариад бид нар эндээ шууд хэлэлцээд явж болно. Тэгэхдээ цаана тэр асуулт тэгвэл нээлттэй үлдэх нь шүү л гэдгийг тал талдаа бодох хэрэгтэй.

2 дугаар асуултыг Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний газрын дарга Эрдэнэсамбуу хариулчих нь зөв байх. 3 дугаар микрофон өгье.

**Я.Эрдэнэсамбуу:** Заяабал гишүүний хариулт, асуултад хариулъя. Төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.13 дахь 10-д заасны дагуу, 13-д заасны дагуу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь энэ хуулийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгж дүн шинжилгээ хийж, дүнг нэгжийн удирдлага нэгдсэн хуралдаанд танилцуулна гэсэн хуулийн заалттай. Тэгэхээр энэ хүрээндээ буюу Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан санал нь хууль зөрчөөгүй гэсэн дүгнэлтийг танилцуулдаг байгаа.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Нэмж, түрүүн 1 минутаа авчихсан. Ганбат гишүүний микрофоныг өгье.

**Д.Ганбат:** Энэ Ерөнхийлөгчийн хоригийг бол талархалтайгаар хүлээн авч байна. Яг хуулийнхаа дагуу энэ бичиг баримтыг ямар хүн боловсруулсан юм бэ? Их сайн боловсруулсан байна. Уншаад л үзэхэд энэ үг, үсэг болгоны цаана бол маш том утга агуулга агуулагдаж байна шүү ер нь бол. Тэгэхээр Улсын Их Хурал бол ямар нэгэн асуудалгүйгээр хүлээгээд авах ёстой. Энэ төсвийг хэлэлцэх үед миний бие бол хэлэлцэхээс нь эхлээд л хэлж байсан. Энийгээ буцааж татаж ав, ийм төсөв чинь явахгүй, болохгүй гэдгийг бол.

Монгол Улсын Үндсэн хуулийг нулимж байгаад л уг нь бол олонх болсон нам бол Засгаа бариад явах ёстой. Үндсэн хуульд тэгж байгаа шүү дээ. Гэтэл үүнийг үл тоогоод, сөрөг хүчингүйгээр удаан явсан, бас энэ Их Хуралд ингэж явах гээд, тэгээд сандал, ширээ суудалд дуртай хэдэн нөхдүүдийг цуглуулаад, ингээд явсан. Тэгээд энэний гай ингээд гарч байна л даа гэж ойлгож байна.

Таамаглаж боломгүй гээд байх шиг байна. Ер нь одоо бол таамаглаж болохоор байна шүү дээ нөхцөл байдлыг бол. Нүүрсний үнэ унаад эхэлчихлээ. Энэ оруулж ирсэн төсөв дээр 129 гэж байсан бол, аль хэдийн 2 орон тоонд ороод ирчихлээ. Валютын нөөц бол багасаад эхэллээ. Өдөр болгон долларын ханш бол өсөж байна шүү дээ 1, 2 төгрөгөөр. Инфляц явж байна. Ийм байдалтай байна.

Тэгээд Ерөнхийлөгчөөс урьд нь бүрэн хориг тавьж байсан удаа байна уу? Монгол Улсын төсөвт тэрийг нэг сонирхоодохмоор байх юм.

2 дугаарт ийм төсвийг оруулж ирсэн энэ цаг хугацаа, энэ хүмүүсийн хөдөлмөр, энийг дагалдаж бас хариуцлага яригдах байх л даа. Хариуцлага яригдах байх. Их олон хуулийг зөрчиж байдаг. Бид нар болохоор ард түмнээ болохоор бол Зөрчлийн хууль, Эрүүгийн хууль энэ бүх юмаар бол шийтгүүл гээд л ингээд яваад байдаг. Ажилчдыг болохоор цалин мөнгийг нь хасаад байдаг. Энэ ЗГ чинь ямар хариуцлага хүлээх ёстой вэ? Манай бүх ард түмнээс сонгогдсон Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн институц юу гэж бодож байна вэ? Энийг бас мэдмээр байна.

Нөгөө талаар бол энэ мега төсөл гэж их яриад байна. Бүр 14 мега төсөл, бараг л өдөр болгон энэ нэмэгдээд байх шиг байгаа юм. Гэнэтхэн нэг өдөр мега төсөл гээд л яриад гараад ирсэн. Урьд нь мега төслүүд гэж яриад байгаа тэр нефтийн үйлдвэр, Дарханы зам ямархуу маягтай яаж дууслаа гэх мэтчилнийг та бүхэн мэдэж байгаа. Та бүхэн энэ мега төсөл дээр бол ямар бодолтой байна вэ? Энэний баахан зураг.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофон.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн 33.1 дэх хэсэг, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12.8 дахь хэсгийн бүрэн эрхийн хүрээндээ хориг тавьсан. Хориг бол Үндсэн хуулийн эрх зүйн онолын хүрээнд хууль тогтоох үйл ажиллагааны бас нэг салшгүй хэсэг. Ийм учраас цоо шинээр хууль тогтоох процесс эхэлж байгаа биш, өөрөөр хэлбэл 1, 2, 3, 4 дүгээр хэлэлцүүлэг, ёсчлох, батламжлах, тэгээд хоригийн хугацаа гэж ингэж ийм нэг цогц цикл цаглавар байгаа. Тэгэхээр энэ дээр ахиад хэлэлцүүлэгт буцааж байгаа Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваад, 90 дүгээр зүйлийн дагуу хэлэлцдэг тийм уламжлалтай.

Монгол Улсын Ерөнхийлөгч нар нийт 6 удаа бүхэлд нь хориг тавьсан юм билээ төсөвт. Тэрнээс нэг удаа хүлээж авахдаа бол ЗГ-т буцааж байсан, тогтоолоор ЗГ-т үүрэг чиглэл өгч буцааж байсан тохиолдол байна лээ. 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд ер нь бол 90.8-ынхаа дагуу хэлэлцээд явах уу, яаж хэлэлцэх вэ гэдэг бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Энийг ХЗБХ болон тэгээд энэ цаглавар цаг хугацааны нөхцөл байдалтай уялдуулаад тооцно биз.

Гагцхүү одоо орон нутгийн төсөв, Монгол Улсын Ерөнхийлөгчид 2019 оны өглөөний 9 цаг 17 минутад ирсэн, 20-ны өдөр нь л хориг тавьсан. Цаглаварын хувьд бол Төсвийн хуульд Дагаж мөрдөх журмын тухай хууль гаргаж, энэ нийслэлийн болон орон нутгийн төсөв өргөн барих хугацаа өнөөдрөөр дуусаж байгаа байх. Түүнийг хойшлуулах тийм шаардлага гарч, 90.8-ын дагуу бол тэгж Дагаж мөрдөх журмын тухай хуулиар өөрчлөлт оруулах шаардлага гарч болзошгүй гэж үзэж байна. Ер нь цаг хугацааны хувьд ч гэсэн энэ онцлог нөхцөл байдлаа харгалзаад, шинээр санаачилж төсөв явж байгаа биш 1, 2 дугаар хэлэлцүүлгээ хийчихсэн, 3, 4 дүгээр хэлэлцүүлэгт нь буцааж байна л гэсэн үг шүү дээ Ерөнхийлөгчийн хориг бол.

Тийм учраас 90.8-аараа, 90.8, 90.9 Дэгийн тухай хуулийн 90.8, 90.9-өөр хэлэлцээд, төсвийн тухай бүх санал дээр ЗГ саналаа өгөх ёстой Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар. Төсвийн зарлагаа нэмэгдүүлж байгаа болон холбогдох саналуудаар. Ингээд хэлэлцээд явах боломжоор хурдан 12 сарын 5-наас өмнө юмаа шийдээд, шуурхайлах боломжууд бол байгаа гэж үзсэн. Дахин тодотгож хэлэхэд 11 сарын 19-ний өглөө 9 цаг 17 минутад Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан. Ингээд 20-ны өглөө 10 цаг 45 минутад Хоригийн тухай албан бичгийг хүргүүлсэн.

**Д.Цогтбаатар:** 4 дүгээр микрофон.

**Б.Даваадалай:** Мега төсөлтэй холбоотой асуулт дээр хариулахад ер нь зарчмын хувьд мега төсөл тэргүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг олон жил ярьсан энэ төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж байгаа. 25 оны төсөв дээр бол 3 төсөл гадаад зээлээр санхүүжиж байгаа, орж байгаа гэж ойлгож байгаа. Хамгийн гол нь бэлтгэл ажил, алхмаа зөв тааруулах юман дээр мэдээж ЗГ, Их Хурал их анхаарах байх гэж бид нар харж байгаа. Ялангуяа өнгөрсөн 20-иод жилийн туршлага бол бэлтгэл ажил, ТЭЗҮ, ажиллах хүчин гээд маш олон бэлтгэл ажил дээр бид нар нэлээн алддаг ийм зөвхөн хувийн хэвшил гэлтгүй нийтлэг ийм зүйлүүд ажиглагддаг учраас олон улсын байгууллагууд, мэргэжлийн зүгээс ч гэсэн нэлээн анхааруулж байгаа.

Тэгэхээр мега төслийн хувьд зарчмын хувьд дэмжиж байгаа. Хамгийн гол нь гадаад зээлийн ашиглалтаа зөв явуулаад ингээд явах юм бол олон жил ярьсан төслүүд хөдлөх нь зөв байх. Алхмаа зөв тааруулж, бэлтгэл ажлаа зөв хангах нь хамгийн гол асуудал байх гэж харж байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Тодруулах уу? Ганбат гишүүний микрофоныг өгье.

**Д.Ганбат:** Би та бүхнээс ийм төсөв оруулж ирээд, ийм цаг хугацаа алдаад ингэж ярилцсаны тэр хариуцлага байх ёстой юу, үгүй юү ямар бодож байна вэ Ерөнхийлөгчийн Тамгын газар маань гэж асуусан л даа. Тэрэнд нэг хариулахыг бодоорой.

Нөгөө талаар бол энэ Улаанбаатарын агаар маш хүнд болсон байна. Нэгэнт Ерөнхийлөгчийн Тамгын газар орж ирсэн болохоор лавлаад асуучихъя. 1 их наяд 500 сая төгрөг тэр түлшинд хий дэмий үр дүнгүй зарцуулсан гэсэн ийм зүйл хотынхон яриад байна. Би бол эхлээд бол хотын агаар бол маш сайн байсан гэж ойлгоод байгаа. Энэ чинь Монгол Улсын хүн бүр хүн болгонд нөлөөлж байна л даа.

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофон өгье.

**Г.Занданшатар:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Тэгээд Үндсэн хуулийн эрх зүйн хүрээндээ Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын харьяанд энэ асуудал харьяалагдана. Энэ асуултын хаяг нь буруу байна. Та ХЗБХ-н дээрээ энэ сэдвээ ярьсан нь дээр байх.

2 дугаарт нь энэ Төсвийн хориг хэлэлцэж байгаа болохоос биш Улаанбаатарын агаарын бохирдол энэ тэрийн асуудлыг бол Улсын Их Хурлын



гишүүд Агаарын бохирдлыг дэд хороо тэр хүрээндээ ярьж хэлэлцвэл зүйтэй байх гэж бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Өгчхөж байгаа юм уу. Баярлалаа. Тэгээд ерөнхийдөө Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах энэ улс төрийн шийдвэрүүд гарсан. Тэгээд энэ дээр нэг л зүйлийг анхаармаар байгаа юм. Яах вэ ер нь зүгээр хэлэлцүүлэгт би буцааж байна гэж ерөөсөө харахгүй байна. Сая бас асуулт, хариултын явцад хэлэлцүүлэгт буцааж байгаа гэж харж байна. Нэгэнт энэ батлагдсан хууль учраас Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан тохиолдолд хэлэлцүүлэг эхэлнэ. Тэгэхдээ энэ хэлэлцүүлгийг ердийн хууль шиг нэг үе шаттай явах уу, Төсвийн хууль өөрөө эргээд хэлэлцэх дэс дараалал нь бол онцгой учраас 4 үе шаттай хэлэлцдэг байсан хуулийг хэдэн үе шатаар явах вэ гэдэг асуудал байгаа. Энэ дээр мэдээж ЗГ-ын оролцоо, Сангийн яам болон бусад яамнуудын оролцоог маш сайн хангаад явах нь зүйтэй байгаа. Энэ зүйлийг би 1 дүгээрт тодотгож хэлмээр байгаа юм.

2 дугаарт Монгол Улсын Ерөнхийлөгчийн өөрийнх нь яг гарын үсэгтэй хориг дээр Үндсэн хууль зөрчсөн Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолыг Улсын Их Хурал баталсан байна гэж үзэж байгаа. Бид энэ хоригийг хүлээж авч байгаа бол энэ тогтоолыг санаачилж оруулж ирсэн хүмүүс хариуцлага хүлээх ёстой. Ийм зүйл байж болохгүй гэдэг зүйлийг жишээ нь цөөн гишүүдээс хэлж байсны нэг нь би. Улсын Их Хурал дээр ганцаараа эсрэг өгсөн. Хэрэвзээ ийм байдлаар юу гэдэг юм тодорхой, Номинчимэг хэлж байсан, Энхбаяр гишүүн хэлж байсан, би нэрийг нь заагаад хэлчихье. Хууль давсан төсвийг тодотгох ёстой нөхцөл байдлууд үүсээгүй байж байхад ингэж чиглэл өгөөд тодотго гэдэг зүйлүүд хийх юм бол энэ олон хуулиуд дээр, олон тусгай горимоор хэлэлцдэг хуулиуд дээр ийм чиглэлүүд өгч болно. Ингэх юм бол бид нар хуульт ёс яриад хэрэггүй.

Тийм учраас энэ Ерөнхийлөгчийн хориг дээр дурдагдсан, бүүр тодорхой заачихсан байна шүү дээ Үндсэн хууль зөрчсөн байна гэдгийг Ерөнхийлөгч хоригоор хэлчхээд байгаа юм. Энэ тогтоолыг орж ирж хэлэлцүүлсэн хүмүүс хариуцлага хүлээх үү? Хүлээх ёстой гэж би хэлж байна. Хүлээх үү гэж би нэгэнт асуулт, хариулт дууссан учраас хүлээх ёстой гэдгээ би Улсын Их Хурлын ХЗБХ-ны протоколд би үлдээмээр байна. Энэ хоригийн араас энэ ажлын хэсэгт орж ажиллах хүмүүсийг сайтар бодох хэрэгтэй. Өнгөрсөн, нөгөө 25 бол ажиллаж болохгүй. Энийг би анхааруулж энэ дээр хэлмээр байна.

**Д.Цогтбаатар:** Да.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

**Да.Цогтбаатар:** Энэ Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулаад энэ Ерөнхийлөгчийн хориг дээр 1 дүгээр хэсэгт нь бол маш ойлгомжтой заачихсан байгаа. Мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж, алдагдалгүй төсөв батлах гээд. Энийг бол яг энэ Улсын Их Хурлын чуулганы үеэр төсөв хэлэлцэж байх үеэр алдагдалгүй төсөв баталъя гэдэг дээр маш олон хэлж байсан гишүүдийнх нь нэг нь би. Тэгээд энэ Ерөнхийлөгчийн хоригийн 1 дүгээр зүйлийн төгсгөл рүү бас энэ төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлах, ЗГ-ын мөрийн хөтөлбөр 2024-өөс 28 оны мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх чиглэлд анхаарах. Намууд бас мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нэг чиглэл өгсөн байна.

Тэгээд энэ ЗГ-аас хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, тэр хөгжлийн хөтөлбөртэй холбоотой мега төслүүдийг бол дэмжиж байгаа. Зөвхөн урсгал зардлын хэмжээнд бид нар таналт хийхэд буюу энэ байр ашиглалттай холбоотой зардал, хангамж, бараа, материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, тэгээд бараа, үйлчилгээний бусад зардал гээд 2016-аас 2023 оны сүүлийн 7 жилийн дундажтай нь харьцуулахад 2 их наяд 800 тэрбум төгрөг хэмнэх боломжтой. 24 онтой нь харьцуулахад 1 их наяд төгрөг хэмнэх боломжтой ийм төсөв 2025 онд орж ирсэн. Тэгээд энэчээгээс нь бид нар хамгийн анхан шатны шаардлага буюу 1,9 их наядыг хэмнэх боломжтой буюу алдагдалгүй төсөв батлах боломжтой байна л гэж нэлээн хэлж явсан.

Тэгээд заавал бид нар энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр заачихсан өрийн хязгаар 2 хувь байна энд нь тааруулсан алдагдал хийе гэдэг дээр санал дэмжээд яваад байх биш, бид нар боломж байгаа нөхцөлд нь хэмнээд, урсгал зардлаасаа хэмнээд, алдагдалгүй төсөв баталчих юм бол Монгол Улсад орж ирэх юу гэдэг юм, энийг чинь дагаад манай Монгол Улсын зээлжих зэрэглэл нэмэгдэнэ, энийг дагаад орж ирэх санхүүжилтийн өртөг багасна. Банкнууд ч гэсэн олон улс дээрээс мөнгө босгоод, бизнесийнхэнд хөрөнгө оруулалтын зээл, эргэлтийн хөрөнгийн зээл өгнө. Иргэдэд бол нөгөө цалингийн зээл чинь ч гэсэн очно, энийг дагаад бүх зээлийн хүү буурах ийм боломжтой байгаад байна гэдгийг л байнга хэлж явсан.

Тэгээд энэ гишүүд бас энд их яриад байна. Энэ ажлын хэсэгт орох хүмүүс нь ингэж анхаарч ажиллаарай гээд. Өмнө нь ажлын хэсэгт орё гэдэг саналаа 2 удаа илэрхийлээд, ажлын хэсэгт орж чадаагүй. Одоо бол би яг энэ урсгал зардлыг танах чиглэлд, хөрөнгө оруулалт, мега төсөл биш зөвхөн урсгал зардлыг танах чиглэлд ажлын хэсэгт орж ажиллах саналтай байгаа гэдгээ бас энд давхар хэлье. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг бол Монгол Улсын Их Хурал болон ЗГ-ыг 2 талаар нь би хашилтад хэлж байгаа юм, аварч байгаа юм. 1 дүгээрт улс төрийн хувьд аварч байгаа юм. Дахиад бүтэн сарын турш төсөв даах ер нь улс төрийн пянгаа ЗГ дийлэхгүй байсан. Улсын Их Хурал ч дийлэхгүй байсан.

2 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн үйл ажиллагааг цаг алдалгүй залруулах боломжийг Төрийн тэргүүн олгож байна. Уг нь төрийн тэргүүний энэ хоригт байгаа үзэл санаа, асуудлуудыг манай Улсын Их Хурлын гишүүд бол Төсвийн хуулийн хэлэлцүүлгийн явцад бол хэлээд л байсан, хэлээд л байсан, яриад л байсан. Тэгэхээр энэ асуудал дээр Улсын Их Хурлын удирдлага, ЗГ дүгнэлт өгөх асуудал байна. Хоригийг хүлээж авсан тохиолдолд манай гишүүд ярьж байна. Сайнзориг гишүүн хэлж байна. Цогтбаатар дарга хэлж байна. Магадгүй хоригийг хүлээж аваад, хоригийг хүлээж авсантай холбоотой төсвийг хэлэлцэх дэг өөрчлөлт оруулах нөхцөл байдал, шаардлага байгааг үгүйсгэхгүй.

Тэр дэгээ баталж байгаад, бид хэлэлцэх ийм шаардлага үүсэхгүй бол сая бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга бол Монгол Улсын Ерөнхийлөгчийг хуульд зааснаар төлөөлөх эрхтэй цорын ганц албан тушаалтан

байгаа. Тэгэхээр сая бол хэлж байна шүү дээ. Хэрвээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт заасан үндэслэл хангагдахгүй бол дахин хориг тавихыг үгүйсгэхгүй гэдэг ийм хариуцлагатай үгийг хэллээ. Тийм учраас энэ дээр Улсын Их Хурал, ЗГ маш нухацтай хандаж, дахин ийм хэлээд байхад ийм Үндсэн хуулиа зөрчтөлөө дүлийртлээ, сохорчихгүй байх тал дээр нь хатуу сануулгыг өгөх ёстой. Энэ дээр би Сайнзориг гишүүнтэй санал нэг байна. Энд ер нь хэн буруутан болж дуусав? Жавхлан бол их талархалтай хүлээж авч байна Ерөнхийлөгчийн хоригийг гэж байна. Их Хурлаа буруутгаж байна лээ шүү дээ. Энэ чинь тийм үг байхгүй юу. Төсвийг баталсан Их Хурлын гишүүд буруутай юм шигээр би бол их талархалтай хүлээж авч байна. Юмаа бэлдчихсэн байсан ухааны юм ярьж байна, өнгөрсөн хойно ярьж байгаа юм. Үгүй шүү дээ. Их Хурлын гишүүд хэлээд байсан шүү дээ.

Сайнзориг гишүүний хэлээд байгаа энэ тогтоол өөрөө Үндсэн хууль зөрчөөд байна, төсвөө баталчхаад тодотгол хийнэ гэдэг ийм тогтоол байж болохгүй гэдгийг чинь хэлээд байсан шүү дээ. Энийг хэн санаачилсан юм бэ? Тэгж ярих юм бол хууль зүйн хувьд алдаагүй гарах хувилбар бол байсан. Би бол Улсын Их Хурлын удирдлагын багт бол саналаа хэлж байсан. 2-т Төсвийн байнгын хороо 3 дахь хэлэлцүүлгээ хийчихсэн байсан. Чуулган хийгээгүй байсан байхгүй юу. 3, 4 дүгээр хэлэлцүүлгийг Байнгын хороо дахиж хийхээр чуулганы хуралдаанаас буцаагаад шийдэх хувилбар байсан байхгүй юу. Хууль зүйн хувьд ийм, өнөөдөр бид нар ийм хориг яриад суухгүй байх боломж байсан юм.

Тэгээд нүд нь тагларчихсан, чих нь дүлийрчихсэн. Төрийн тэргүүн хэлж байж онгойдог манай энэ Жавхлангаас эхлүүлээд. Төрийн тэргүүн сануулж хэлж байж нэг юм за гэдэг. Монгол Улсын парламент дээр гишүүд нь хэлээд, хэвлэлийн хурал хэлээд, бизнес эрхлэгчид нь хэвлэлийн хурал хийгээд, тоо, үндэслэлээ шаардаад байхад таг дүлий. Ингэтлээ сохорчихсон байгаа байхгүй юу. Ингэтлээ данхайчихсан байна гэсэн үг. Данхайчихсан газар нь ер нь данхайгаад байгаа бол сануулга цэгийг нь тавих газар нь бол парламент шүү. Тэгэхээр парламент энэ ажлаа бас хийх ёстой шүү энэ давхар.

**Д.Цогтбаатар:** Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье. Алдаржавхлан гишүүн үг хэлье гээд дарсан юм байна, энэ нь орохгүй байгаад байна. Манай энэ техникийн албаныхан энийгээ бас анхаараарай.

**Ж.Алдаржавхлан:** Орсон юм, устгачих шиг боллоо, цаанаас устгачхав уу яав. Би 3 зүйлийг хэлэх гэсэн юм. Энэ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахаар авч таарна тийм ээ. Авахаар Их Хурал нь ч нэг сонин харагдах юм байна лээ мэдсээр байж байгаад баталчихсан. ЗГ энэ сонин харагдах юм байна лээ мэдсээр байж байгаад өргөн барьчихсан. Нэг ийм сонин байдал руу орох юм байна лээ дээ.

Би бол нэг ийм саналтай байна ХЗБХ-н даргаа. Сая Энхбаяр гишүүн ер нь хөндчихлөө шүү дээ. Энд нэг хүн болохоор 2 үе шаттай явна гээд байгаа юм. Тэндээс төсөв хэлэлцдэг зарчмаар 4 үе шаттай явах ёстой гэж байгаа юм. Тэгээд аль нэгээр нь явахаар тэндээс 3 дахь хүн үгүй ээ энэ чинь буруу байна гээд маргахаар маргах юм биш биз дээ. Тэгэхээр дэгдээ яаралтай өөрчлөлт оруулж, энэ төсвийг бүхэлд нь хориг тавьсан үед ийм дэгээр явна гэсэн нэг асуудлаа нэг тийш нь болговол яасан юм бэ гэсэн би нэг зарчмын саналтай байна. Энийг та, албан ёсоор би Улсын Их Хурлын гишүүний хувьд санал гаргаж байна.

3 дугаарт энэ ажлын хэсэг гээд нөхдүүд байна. Хаанаас яаж томилогдсон ажил бүү мэд, хэнээс, яаж санал авсан юм бүү мэд, баахан хүмүүс орж ажилласан байдаг юм. Тэгээд энэ ажлын хэсгийг шинэчлэн байгуулбал яасан юм бэ гэсэн би саналтай байгаа юм. Ажлын хэсгийг шинэчлэн байгуулаад, энэ орох хүсэлтэй улсуудыг нь оруулаад, сайн ярилцахгүй бол хэсэг бүлэг хүн тэнд орчихсон тэгээд нэг нэгнийгээ баахан муулаад, сүүлдээ энэ Даваасүрэн гэдэг хүнээс муухай хүн Монгол Улсад байхгүй болж таарч байна шүү дээ. Тэгэхээр тийм байдал руу оромгүй юм байна лээ. Тэгэхээр шинэ ажлын хэсгийг шинээр зохион байгуулаад, ХЗБХ-ноос бас 2, 3 гишүүдээ та оруулах чиглэлээс ажиллаач. Миний хувьд орж ажиллах тийм хүсэлтэй байгаа.

Эхний төсөв дээр би бол анх шинээр сонгогдсон гишүүн учраас энэ ах нарыгаа харъя даа гээд чимээгүй сууж байсан. Одоо энэ Төсвийн тодотгол дээр орж ажиллах бол сонирхолтой байна гэдгийг хэлье. Ийм зүйлүүд дээр анхаарч өгөөч гэж хүсэж байна. Хамгийн чухал нь тэр дэгийн асуудлаа нэг тийшээ болгохгүй бол иргэн Б очоод та нар буруу хуулиар хэлэлцсэн байна шүү дээ гээд Үндсэн хуулийн цэц дээр гаргахад энэ асуудал чинь явах юм биш биз дээ гэж. Ер нь ирээдүйд гарах янз бүрийн үр дагавраас нэгэнт яаралтай горимоор хагалбал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

**Д.Цогтбаатар:** Саяын энэ Алдаржавхлан гишүүний хэлсэн саналуудыг манай Байнгын хорооныхон тэмдэглээд аваарай. Энийг тэгээд зохих журмаараа холбогдох Тамгын газар, Их Хурлын удирдлага эд нарт ингээд уламжилж өгөх ёстой байх. Яг манай энд бол бидэнд саяын таны ярьсан асуудлыг манай Байнгын хорооны асуудал биш учраас тэмдэглэж аваад л, цаашаа уламжлах байх. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

**Г.Уянгахишиг:** Түрүүн бас юу яаж чадсангүй, Алдаржавхлан гишүүнтэй адилхан. Тэгэхээр яах вэ одоо яг ийм нөхцөл байдалд хүрчихсэн нь бол маш харамсалтай байна. Өөрөөр хэлэх юм бол аль 9 сарын 1-нээс эхлээд л төсөв өргөн баригдсанаас хойш Их Хурал 4 удаа хэлэлцлээ. Энэ хооронд Байнгын хороод өчнөөн хэлэлцүүлэг хийлээ. Энэ хооронд Их Хурлын гишүүдийн зүгээс ч гэсэн зардлыг танахтай холбоотой, мөн түүнчлэн хууль тогтоомж Тогтвортой байдлын хуулийг зөрчих магадлалтай юмнууд байна, хууль зөрчөөд байна, энийгээ эргэж хараач гэдэг энэ асуудлыг ЗГ-т удаа дараа тавьж байсан.

Гэтэл өнөөдөр Их Хурлаас төсвөө баталчхаад, Ерөнхийлөгчийн хориг тавиулчихсан байна гэдэг бол энэ үнэхээр харамсалтай байна. Нөгөө талаас бас нэг бид нар анхаарч үзэх ёстой асуудал өнөөдөр бид нар Ерөнхийлөгчийн хоригийг хүлээгээд авах юм бол энэ төсөв өөрөө хууль зөрчсөн байна гэдгийг бид нар хүлээн зөвшөөрч байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл яг хориг тавьсан агуулгыг харахаар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн хуулийг зөрчсөн байх, мөн Үндсэн хуулийг зөрчсөн байх ийм магадлалтай байна гэдэг нөхцөл байдлуудыг дурдсан байгаа. Тэгвэл бид нар Дэгийн тухай хуулиа харах юм төсвийн хэлэлцүүлгийн нэгдүгээр хэлэлцүүлэг дээр хэрэв хуульд нийцээгүй байх юм бол Их Хурал буцаах үүрэгтэй, буцааж шийдвэрлэдэг тийм ээ, дүгнэлт гардаг.

Тэгэхээр хэрвээ хоёрдугаар хэлэлцүүлэг дундаас ч гэдэг юм уу буцаагаад энэ өмнө өргөн баригдчихсан төсвөө дахиад хэлэлцээд эхэлнэ гэх юм бол бид нар нөгөө хууль зөрчсөн гэдэг агуулгаар нь хоригийг нь хүлээн зөвшөөрчхөөд, буцаагаад нэгдүгээр хэлэлцүүлгээ алгасаад явчхаж болохгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр дараа нь цаашдаа тэр дэг ямар ч байсан тодорхой болгоод, Энхбаяр гишүүний хэлснээр, Сайнзориг гишүүний хэлснээр дэг дахиад тодорхой болгож орууллаа гэхэд өнөөдөр Их Хурал өөрөө буцаагаад төсвөө шууд буцаасан төсвийг ЗГ-т өгч засуулахгүйгээр, буцаагаад дундаас нь аваад хэлэлцэнэ гэдэг бол энэ өөрөө гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал хоёрын хоорондын эрх мэдэл хуваарилалтыг зөрчих ийм том асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ талаасаа бид нар сайн бодолцох ёстой болов уу гэдгийг бас сануулж хэлмээр байна.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Би нэг цөөхөн зүйл хэлмээр байна. Ерөнхийлөгчийн оруулж ирж байгаа энэ хоригийг бол дэмжиж байгаа. Энэ дээр Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын сая танилцуулга дээрээс их чухал хэдэн санаа гарч байгаа юм шүү. Энийг ингээд ЗГ өөрөө цаашдаа үйл ажиллагаандаа анхаарах ёстой юм. Энэ төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төсвийн алдагдал, ЗГ-ын өрийн тусгай шаардлагыг хангана гэсэн зорилтоо бодит хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тэргүүн сануулж байна гээд.

Тэгээд энэ дээр би нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Бид нар жишээлбэл Хэмнэлтийн хууль гээд Хэмнэлтийн хууль батлаад, нэг хэдэн жийп эд нарыг нь болиулангуутаа хэмнэчихлээ гэсэн боловч яг үнэндээ хэмнэлт байсан уу, үгүй юу гэдгийг аваад үзэх юм бол Төсвийн хууль төсөв хэзээ ч багасаж орж ирээгүй байхгүй юу. Энэ хууль гарсны дараа төсөв тэлээд л байсан, тэгж хэмнэхгүй шүү дээ. Тэгэхээр энийг бол Ерөнхийлөгчийн Тамгын газраас ингээд гярхай ажиглаж, хэлж байна л даа. Энийг чинь хэлэхгүй яваад байгаа байхгүй юу. Тэгээд хүмүүс нь болохоор Хэмнэлтийн хууль гаргачихсан болохоор хэмнэчихсэн гэж бодоод байдаг.

Тэгсэн бодит байдал дээрээ хэзээ ч хэмнээгүй байж болохгүй шүү дээ энэ чинь. Төсөв нь улам тэлээд байсан гэдэг чинь хэзээ ч хэмнээгүй байхгүй юу. Тэгэхээр энэ чинь Засаг иргэдтэйгээ харьцахдаа бодит үнэнийг ярьж, хэлснээ хийж л харьцана уу гэхээс хийсэн юм шиг бодогдуулаад, хийгээгүй яваад байна гэдэг чинь бол үнэхээр энэ засаг иргэд, Засгийн хоорондын итгэлцлийг алдагдуулах маш том эрсдэлийг дагуулж байгаа үйлдэл байгаа юм. Тэгэхээр энийг бид нар одоо цаашаа тэр хэмнэлт гэдэг юман дээрээ тэр хууль чинь илүү их хүчин төгөлдөр хэвээрээ байгаа бол миний санаж байгаагаар хүчин төгөлдөр хэвээрээ байгаа. Жишээлбэл алдагдалгүй болго гэдэг чинь яг энэ хуулиа хэрэгжүүлэхийг л наад зах нь хэлж байгаа байхгүй юу.

2 дахь зүйл нь энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг хязгаарла гээд би 2 жил ярьж байгаа юм. Яг энэний тэр тайлбар дотор бол төрийн өмчит ААН-үүд болон нэмээд төсвийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ чинь 70 хувь болчихлоо ингээд яваад байж болохгүй гээд 2 жил хэлсэн. Тэгээд эцсийн дүндээ хориг дээр ирж энэ үнэндээ гүйцэгдэж байгаа байхгүй юу. Яагаад гэвэл энэ гудамжинд бизнесүүд яагаад гарч ирж байна вэ гэхээр энэ дарга нарынх нь зардал нэмэгдээд байдаг, бизнесүүдийн орлого багасаад байхаар яаж бизнесүүд дэмжих юм бэ? Энэ чинь гарч ирээд хэлэх нь зүй ёсны хэрэг болчихож байгаа байхгүй юу.

Өөр нэг зүйлийг зүгээр энэ дээр онцлоод хэлмээр байна. Би нэгдсэн чуулган дээр ч хэлнэ гэж бодож байгаа энэ. Энд Үндсэн хуулийг л өөрчилж байхад төсөв чинь нэмэгдэнэ шүү, тэгээд нэмэгдсэн ч гайгүй шүү дээ гээд, би тэгээд 30 жилээр нь аваад үзээрэй гэхэд энэ яасан тэнэг хүн бэ, 30 жилээр ийм юу тооцно гэж юу

байдаг юм. Төсвийг чинь нэг жилээр л хэлэлцдэг юм гээд л байсан. Тэгэхдээ 30 жилээр харвал энэ төсөв чинь маш том болно шүү гээд яриад байсан, 30 жил хүлээх шаардлага гарсангүй, 366 хонолгүйгээр энэ чинь ийм том төсөв байна гээд хүмүүс дургүйцээд гараад ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө хааяа цөөдөөд миний дуу хүрдэггүй юм байлгүй. Сая ерөөсөө 2 долоо хоног, 2 жил ярихад хэн ч энийг дэмжээгүй байж, 2 долоо хоног ярихад бол юу болов. Энэ чинь тэгээд хоригдоо хүрч байна шүү дээ. Тэгэхээр аливаа зүйлийг яг нөгөө бодит үнэнтэйгээ нийцүүлж ярьж байхгүй бол үнэндээ хэзээ нэгэн цагт гүйцэгддэг гэдгийг хэлмээр байгаа юм.

Энэ дээр харин сая гишүүд маань яриад байна. Энэ Их Хурал буруутай юу эд нар гээд. Тэгэхээр энэ дээр чинь нэг юм би хэлмээр байна. Алдагдалгүй төсөл оруулаад ирсэн чинь бид нар алдагдалтай болгоод явуулчихсан бол энэ бол асуудал. Эхнээсээ алдагдалтай оруулаад ирчихсэн байгаа төсвийг, яг үнэндээ бол төсөв том өөрчлөгдөөгүй шүү, угаасаа хэзээ ч тэгж өөрчлөгддөггүй. Одоо энэ Их Хурлын гишүүдийн эрхийг таначихсан нөхцөл байдлаар чинь бүүр өөрчлөгдөхөө больчихсон байхгүй юу. Яг тэрүүгээрээ л явсан. Тэгэхээр энэ дээр Их Хуралтайгаа хариуцлага тооцно гээд ингээд, орж ирснээр нь л батлаад бараг явуулж байгаа байхгүй юу. Харин ч хэлэлцээд гишүүд маань зөндөө энэ дотор ярьсан байна нэг.

2-т би зүгээр нэг юугаа хэдүүлээ бодох хэрэгтэй байх. Ингээд бие бие рүүгээ Их Хурал дотроо асуудал ярина гэдэг бол хэцүү. Яагаад гэхээр ийм байхгүй юу. Хориг гэдэг бол их хууль, Их Хурал хууль зөрчихлөө гэсэн үг биш. Түрүүн Занданшатар дарга хэлж байна шүү дээ. Хориг гэдэг бол хууль тогтоох процессын салшгүй хэсэг. Энэ чинь өөрөө хууль болоогүй байгаа байхгүй юу. Энэ хориг батлагдтал, тэгэхээр энэ дээр Их Хурал алдаа гаргаж болзошгүй гэж хууль өөрөө хүлээн зөвшөөрөөд, энийг нь хянах боломжийг нь Ерөнхийлөгчид олгоод өгчихсэн хууль байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр Ерөнхийлөгчийн хориг тавьж байна гэдэг бол хүүе хаая гээд давхиж орж ирээд, хүн болгон дээр хариуцлага тооцоод байх асуудал биш. Хуулийн хэлэлцүүлгийн процесс л явж байгаа нь энэ. Харин тэгээд тэр функцээ биелүүлж байна шүү дээ. Алдаатай гарч болзошгүй юмыг замд нь зогсоогоод, одоо Их Хурал аваад хэлэлцэнэ.

Харин тэгэхдээ бид нар хаашаа энийгээ аваачиж хэлэлцэх вэ гэдэг чинь нээрээ л нээлттэй асуудал байгаа шүү. Энэ дээрээ тэгээд бүгдээрээ тал талаасаа саналаа ярилцана биз. Энэ тэгэхдээ тусдаа асуудал. Одоо бол хориг хүлээж авах тухай асуудал хэлэлцэж байгаа. Ингээд хэлэлцэх асуудал дээрээ Их Хурлын, тийм саналаа хураачихъя. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан асуух асуулттай гишүүд асуултаа асууж дууссан. Үг хэлэх гишүүд үгээ хэлж дууслаа. Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг тийм, уучлаарай.

Монгол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж, баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 92,9 хувиар санал дэмжигдлээ. Тэгээд Номинчимэг гишүүн бас дэмжсэн байна. Номинчимэг гишүүнийг дэмжсэнд тооцож, энэ хувь хэмжээгээ оруулаарай. 1 дүгээр асуудал хэлэлцэж дуусла. Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан, дараагийн асуудал байгаа шүү. Их Хуралд, чуулганд Номинчимэг гишүүн танилцуулъя.

14.21 цаг

Ганц санал хураалт. Манайхан түр байж байгаарай. Ганц санал хураалт. 2 дугаар асуудалдаа оръё. Энэ нөгөө, Энхбаяр гишүүнээ, Сайнзориг гишүүнээ ганц минут ганц асуудал хэлэлцээдэхье тэгэх үү. Тийм, санал хураалт байгаа. Отгонбаяр гишүүнээ, манайхан сууж байгаарай. 2 дахь асуудлаа бид нар хэлэлцэнэ шүү.

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай/***

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын товыг тогтоох тухай Байнгын хорооны төслийг хэлэлцье. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу, нэрсээ өгнө үү? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Тэгэхээр тогтоолын төсөл дээр ер нь их хялбар юу орж байгаа. Нөгөө 6 гээд, 12 сарын 6-нд сонсгол хийе гэсэн шүү дээ. Тэгээд тэр ерөөсөө гишүүдийн ирц юмнууд бүрдэж өгөхгүй байгаад байгаа юм. Тийм учраас 11 болгож хойшлуулж байгаа ердөөсөө л энэ. Тэгээд энэ хуулийн бусад, тийм, тэгээд хуулийн бусад юутай хэмжээ цаглавартайгаа яг таарч байгаа.

Ингээд Томилгооны сонсголыг тогтоох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 86,7 хувиар дэмжигдлээ. Сайнзориг гишүүн бас дэмжсэн байна. Сайнзориг гишүүнийг дэмжсэнд бүртгэж аваарай. Баярлалаа.

14.23 цаг

Өнөөдрийн хэлэлцэх асуудлаа дууссан тул Байнгын хорооны хуралдаан дууслаа. Гишүүддээ талархал илэрхийлье.

***ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ***

***Д.УЯНГА***